



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 614

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн санхүүжилтээр баригдсан 704,928,863.00 (долоон зуун дөрвөн сая есөн зуун хорин найман мянга найман зуун жаран гурван) төгрөгийн үнэ бүхий дулаан хангамжийн байгууламж ЦТП, 447,441,324.00 (дөрвөн зуун дөчин долоон сая дөрвөн зуун дөчин нэгэн мянга гурван зуун хорин дөрвөн) төгрөгийн үнэ бүхий цэвэр усан хангамж, ариутгах татуургын тоног төхөөрөмжийг нийслэлийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Дулаан хангамжийн байгууламж ЦТП болон цэвэр усан хангамж, ариутгах татуургын тоног төхөөрөмжийг нийслэлийн өмчид хүлээн авч, эзэмшигчийг тогтоон, данс бүртгэлд тусгуулахыг Нийслэлийн өмчийн харилцааны газар /Ч.Одناسан/-т даалгасугай.

3. Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга Ч.Одناسан, "Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:


3.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

3.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

 Б.ГАВАА